

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

2021 оны 08 дугаар сарын 01

Дархан

Барилга, хот байгуулалтын сайдын багцаас хэрэгжиж буй “Тосгон чиглэлийн гадна дулааны шугам /Дархан-Уул, Дархан сум” ажлын зураг төсвийн үнэ 13,077,644.0 төгрөгийн санхүүжилтийг “Инж байгууламж” ХХК-д, захиалагчийн хяналтын зардалд 4,238,449.0 төгрөгийн санхүүжилтийг “ДХББЗГ” ОНӨААТҮГ-т, 4,238,449.0 төгрөгийн санхүүжилтийг Барилгын хөгжлийн төвд

Эрүүл мэндийн сайдын багцаас хэрэгжсэн “Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж /багц-3/” нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 389,800,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Си Ай Ти” ХХК-д тус тус олгосон.

Дархан сумын Өргөө багийн явган зам, ногоон байгууламж, тохижилтын ажлын бараа материал нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 19,991,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Мөнх-Од цацрал” ХХК-д,

“Зураг төсөл боловсруулах” төсөл арга хэмжээ, Хүүхдийн төмөр замын цогцолборт шинээр баригдах төмөр зам болон барилга, байгууламжийн тэг шугам, цэгүүдийг тодорхойлох ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 5,220,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Ёлт сүрвэй” ХХК-д тус тус олгосон.

Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 30,000,000.0 төгрөг, Хонгор сумын ОНХС-ын дансанд 100,000,000.0 төгрөг, Шарын гол сумын ОНХС-ын дансанд 120,000,000.0 төгрөг, Орхон сумын ОНХС-ын дансанд 66,000,000.0 төгрөг тус тус олгосон.

/Тогтвортой амжиргаа-3 төслөөс сумдын Олон улсын байгууллагаас Орон нутгийн хөгжлийн санд олгох урамшуулалд 430,054,165.0 төгрөгийн санхүүжилт ирсэн./

Залуучууд хөгжлийн төвийн дээвэр засвар /Дархан сумын 11 дүгээр баг/ ажил 94 хувийн гүйцэтгэлтэй тул 25,033,959.0 төгрөгийн санхүүжилтийг “Уужим хүслэн” ХХК-д, захиалагчийн хяналтын зардалд 505,741.0 төгрөгийн санхүүжилтийг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т

Аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын засварын ажил 63.9 хувийн гүйцэтгэлтэй тул 57,856,276.0 төгрөгийн санхүүжилтийг “Эйч би эс” ХХК-д, захиалагчийн хяналтын зардалд 1,050,214.0 төгрөгийн санхүүжилтийг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т

Наадмын талбайд асар нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 16,000,000.0 төгрөгийн санхүүжилтийг Бурхантын бүтээлч бүсгүйчүүд хоршоонд

Нийтийн аж ахуй, үйлчилгээний газарт хог тээврийн авто машин нийлүүлэх ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 127,480,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Нано планет” ХХК-д тус тус олгосон.

“Дөрвөн замын уулзварын гэрлэн дохио /Дархан сум” ажил 100 хувийн гүйцэтгэлтэй тул 98,081,742.0 төгрөгийн санхүүжилтийг “Лэд сити” ХХК-д, зураг төсвийн үнэ 4,800,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Засмал зам” ХХК-д,

захиалагчийн хяналтын зардалд 1,408,402.0 төгрөгийн санхүүжилтийг “Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-т тус тус олгосон.

“Ногоон Дархан” төслийн хүрээнд модны суулгац худалдан авах ажлын гүйцэтгэлд 1,800,000.0 төгрөгийн санхүүжилтийг Моностой нөхөрлөлийн ахлагч Г.Цэдэндашид, 3,968,000.0 төгрөгийн санхүүжилтийг иргэн Ц.Нарангэрэлд, 2,505,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Батбадрах дэлгэр” ХХК-д тус тус, бордоо нийлүүлэх ажлын гүйцэтгэлд 10,000,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Ногоон Агула” НҮТББ-д,

“Хар шороо нийлүүлэх” ажилд 4,007,700.0 төгрөг

“Хориотой ургамлын устгал хийх” ажилд 10,000,000.0 төгрөгийн санхүүжилтийг Цагдаагийн газарт,

“Мониторинг судалгаанд шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдах /GPS-1 ширхэг, зургийн аппарат 1 ширхэг/” ажилд 1,150,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Инженер геодези” ХХК-д, 2,310,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Модон завь” ХХК-д,

“Шилмүүст модны ойжуулалт” ажилд 6,950,000.0 төгрөгийн санхүүжилтийг “Домогт Шарын гол” ХХК-д тус тус олгосон.

Эрүүл мэндийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIX.3.5-д, орон нутагт эрх шилжин хэрэгжиж байгаа “Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх /Дархан-Уул, Дархан сум/ Багц-2” төсөл арга хэмжээний УТХО2020-01/21+1 дугаартай 225,000,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй “Сетунари” ХХК-ийн гүйцэтгэсэн гэрээт ажлын 100 хувийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XV.1.1.38-д орон нутагт эрх шилжин хэрэгжиж байгаа “Хонгор сумаас Салхит баг хүртэлх авто зам, 13.1 км /Дархан-Уул, Хонгор сум/” төсөл арга хэмжээний УТХО2020-01/32+1 дугаартай 2,049,418,940.0 төгрөгийн төсөвт өртөгтэй “Жи Пи Экспресс Финанс” ХХК-ийн гүйцэтгэж буй гэрээт ажлын 80.0 хувийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулж ЗТХЯам-д хүргүүлсэн.

УТХО-с нийт 17 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 17 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендерт шалгарсан 12 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

ОНТХО-с нийт 40 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 38 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 26 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

ОНХС-с нийт 10 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 10 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 6 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

Замын сангаас нийт 2 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 2 төсөл арга хэмжээний бичиг баримтыг ОНӨГ-т хүргүүлж, тендер шалгарсан 2 хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан.

2021-2022 онд өвөлжих, хаваржих малын тоо, шаардагдах тэжээлийн хэрэгцээ, хадлан тэжээл бэлтгэх даалгаврыг тооцож сумдад даалгавар болгон хүргүүлсэн. 2021-2022 онд 4 сумын хонин толгойд шилжүүлснээр 610653 толгой мал өвөлжих бөгөөд шаардагдах 58622,7 тонн байгалийн хадлан бэлтгэх тооцоо гарсан байна.

Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, малын үүлдэр угсааг сайжруулах, орон нутгийн өмчлөлд шинээр мал худалдан авах болон мал худалдан борлуулах үүрэг бүхий 2021 оны 7 сарын 8-ны 01-А/207 тоот Аймгийн Засаг захирамжийн ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд хуралдаж Сэлэнгэ үүлдрийн 48 толгой бярууг худалдан борлуулах ажлыг зохион байгууллаа.

Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Хонгор сумын хар бэлчирт үхрийн аж ахуй, Орхон сумын Ноёнхонгорт туслах аж ахуй эрхлэх сонирхолтой иргэн, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцох төслийн урилга боловсруулан нийтийн цахим сүлжээнд тавьсан бөгөөд нийт 16 материалыг хүлээн авлаа.

Японы Жайка Олон Улсын байгууллагаас цар тахал гарсантай холбогдуулан “Зөгийн аж ахуйн гарын авлага”, “Зөгийн аж ахуйн бизнес менежментийн гарын авлага” номыг Орхон, Шарын гол, Дархан сумдын зөгийчдөд хүргүүлж ажилласан.

Мал үржлийн албаны 2021 оны эхний хагас жилд зохион байгуулсан ажлын тайланг хүснэгтийн дагуу гаргаж ХХААХҮЯамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар tamiraa138@gmail.com хаягаар хүргүүлээд байна.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу Дархан сумын Найрамдал талбай дээр мал, махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулагдаж нийт 3 сумын давхардсан тоогоор 28 малчин 419 толгой хонь, 77 толгой ямаа 51 ширхэг хонь, ямааны гулууз худалдан борлуулсан байна.

Өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас Дэлхийн банкны санхүүжилтээр Үндэсний статистикийн хорооны 2020 оны мал тооллогын бүртгэлд бүртгэгдсэн тус аймгийн 4 сумын 1323 малчин өрхөд 100,000 мянган төгрөг олгохоор шийдвэрлэсний дагуу 4 сумын 63 малчин өрхийн дансны мэдээллийг ХХААХҮЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлээд байна.

4 сумын тохироогоор дутагдаж буй хээлтүүлэгчийг малын төрөл бүрээр гаргаж нөхөн тавих шаардлагатай хээлтүүлэгчийн судалгааг гаргаж ХХААХҮЯамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хүргүүлээд байна.

Монгол Улсын засгийн газрын 2019 оны 343 дугаар тогтоолоор батлагдсан “Хонь, тэмээний ноос бэлтгэж үндэсний үйлдвэрт тушаасан малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу тус аймаг 4 сумын 386 малчинд ноосны урамшуулал олгохоор тооцоог ХХААХҮЯаманд хүргүүлсэн. Одоогийн байдлаар 4 сумын нийт 314 малчны урамшуулал шилжсэн бөгөөд бусад малчдын залруулга гүйлгээ хийх ажлыг ХХААХҮЯамны Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлээд байна.

Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Яамаас ирүүлсэн орон нутагт хонины ноос бэлтгэх 112, тэмээний ноосны бэлтгэх 21 үндэсний үйлдвэр ноос бэлтгэх нэрсийг цахимд байршуулан сумдад чиглэл хүргүүлэн ажиллаж байна. Цаашид онд е баримт

болон падаан хосолсон хэлбэрээр урамшуулал зохион байгуулах бөгөөд ноос бэлтгэлийн ажил дуусч сумдад тайлангаа авч эхлээд байна.

Хүнсний боловсруулах 59 хүнсний үйлдвэр, Орхон сумын 13, Хонгор сумын 20, Шарын гол сумын 33, Дархан сум 245 хүнсний дэлгүүрийн үнэ, бүтээгдэхүүний үлдэгдлийн мэдээг 7 хоног бүрийн 1, 4 дахь өдрүүдэд тогтмол авч, хангамжийг хоногоор тооцож, ХХААХҮЯ, аймгийн Онцгой байдлын газарт 53 дахь удаагаа хүргүүлэн ажиллав. 2021.07.22-ны байдлаар хангамж тооцоход малын мах 3.96, гурил 1511.8, гурилан бүтээгдэхүүн 3.08, сүү, сүүн бүтээгдэхүүнээр 16.21, төмс 7.7, хүнсний ногоо 6.49, будаа 22.47, тос 36.6, элсэн чихэр 105.61, давс 93.48, өндөг 2.6, савласан цэвэр ус 1.74, цай 1.33 хоногийн нөөцтэй байлаа.

Аймагт үйл ажиллагаа явуулж буй 3 гурилын үйлдвэрт буудайн үлдэгдэл нийт 50531.8т, хивэг 10084.2т үлдэгдэлтэй байна. Тээвэр Дархан ХХК-ийн хүнсний захын махны тасагт мал, мах бэлтгэгч нар 2021.01.23-2021.06.30-ны хугацаанд нийт 362.7 тн мах нийлүүлснээс 253.9 тн борлуулсан ба үлдэгдлийг үйлдвэр, цехэд борлуулсан байна. 2021.07.01-2021.07.19-д нийт 60.2т мах нийлүүлж, 42.1т борлуулснаас зөвхөн 2021.07.19-ний өдөр 0.79т мах борлуулж, 0.33т үлдэгдэлтэй байлаа.

Дархан-Уул аймгийн томоохон худалдааны 15 газар, агуулахын худалдаа 12, Орхон сумын 13, Хонгор сумын 20, Шарын гол сумын 33, Дархан сум 228 аж ахуйн нэгжээс бүтээгдэхүүний үнэ, үлдэгдлийн судалгааг 50 нэр төрлөөр 7 хоног бүрийн Даваа, Пүрэв гаригт гар утсаар болон цахимаар авч ажилласан. Үүнээс: Дархан-Уул аймгийн томоохон худалдааны 15 газар, агуулахын худалдаа 12 байгууллагаас мэдээг утсаар болон цахимаар тогтмол авсан.

Хөнгөн, жижиг дунд үйлдвэр, ахуй үйлчилгээ, хоршооны салбар: Энэ хоёр 7 хоногт нийт 8165 ш арьс шир бэлтгэсэн байна. Адууны арьс 5.0 мянган төгрөг, үхрийн шир үнэ 3.0-5.0 мянган төгрөг, ямааны арьс 0.5 мян.төг, хонины арьс өлөнтэйгээ 4.0 мян.төг байна. Ноос 1кг нь 1500 төгрөгийн үнэтэй 157.5тн бэлтгэсэн байна. Модон материал зүсмэл 238м³, түлээний мод 225м³ бэлтгэсэн байна.

Ажлын байр дэмжих хөнгөлөлттэй зээлээс аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 566 иргэн, 132 аж ахуйн нэгжид 41.16 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай олгож, 7 аж ахуйн нэгжид 1.7тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2503 ажлын байр хадгалагдлаа.

СХС-ийн зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг шинэчлэхээр мэдээллийн санд шивэлт хийж тулгах, зээлээ хугацаандаа төлөөгүй зээлдэгч нартайгаа холбогдож мэдэгдэл өгөх, программын тулгалтыг хийх зэрэг сумын мэргэжилтнүүдтэй хамтран ажилласнаар мэдээллийг нэгтгэж, төв сервирт эцсийн байдлаар дамжууллаа. Хагас жилийн байдлаар нийт 212 иргэн аж ахуйн нэгжээс муу түүхтэй 82, эргэлзээтэй 11, хэвийн бус 4, хугацаа хэтэрсэн 5, хэвийн ангилалтай 110 зээлдэгч байна.

Гадаад харилцааны яам, ЖДҮГ, Монгол Улсаас Япон Улсад суугаа элчин сайдын яам, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв, Экспорт Олон улсын худалдааны төв ТББ-ууд хамтран 2021 оны 06.25-07.05-ны хооронд Монгол-Японы-Эдийн Засгийн түншлэлийн хэлэлцээрийн 5 жилийн ойн цахим форум, үзэсгэлэнд аймгийн танилцуулгыг аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлан

хийж, 8 үйлдвэрийн мэдээллийг үзэсгэлэнгийн танхимд байрлуулж, 100 гаруй бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан ажиллалаа.

“Түншлэлийн хөтөлбөр 2021 оны 2-р цонх” Экспортыг дэмжих төслийн нээлт хийгдсэнтэй холбогдуулан жилийн 150.0 сая төгрөгийн борлуулалтын орлоготой 2-оос дээш жил үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн бус, аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл, мэдээлэл технологийн салбарын аж ахуйн нэгжид хүргэж, экспортод бүтээгдэхүүнээ гаргах боломжтой 10 аж ахуйн мэдээллийг гаргаж хүргүүллээ. Мөн World Bank Mongolia - Дэлхийн Банк "Түншлэлийн хөтөлбөр 2.0" цахим уулзалтад 07 сарын 02-ны өдөр хамрагдлаа.

ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээл авсан 2017-2020 оны 28 зээлдэгч нарт 2021 оны 7-р сарын 8-22-ны өдрүүдэд аймгийн дэд хорооны ажлын хэсгээс хяналтыг хийж гүйцэтгэхээр “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2017-2020 онд олгогдсон хөнгөлөлттэй зээлд хамрагдсан зээлдэгчийн үйл ажиллагаатай танилцах ажлын удирдамж”-ийг боловсруулсан ба хугацааг хойшлуулж, 8-р сард гүйцэтгэхээр хойшлуулаад байна.

Зээлийн батлан даалтын сангийн хөнгөлөлттэй зээлийн мэдээллийг 2-р улирлын байдлаар 4 удаагийн сургалтаар 88 иргэдэд хүргэж, ажлын байр дээр 74 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласнаар Хөтөлийн Занар ХХК, Цагаан сувдан сондор ХХК, Цэнгүүнбаяр ХХК, Өсөх баян бүрд хаус ХХК, Мөнх-Аялгуу ХХК, Идэр түшиг ХХК, Хермоны шүүдэр ХХК, Арцат Алтайн Уулс ХХК, Дархан Илч ЗБН, Хос-Анар ХХК, Хайрхан Түшиг ХХК зэрэг нийт 11 аж ахуйн нэгж зээлийн батлан даалтын сангийн 1945.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, гэрээг байгууллаа.

“Хоршооны 100 жилийн ой”, “Ахуйн үйлчилгээний 90 жилийн ой”-н арга хэмжээтэй холбогдуулан төрийн шагнал, салбарын шагналд нэр дэвшиж буй Мэргэжлийн холбоодоос ирүүлсэн 16 иргэний материалыг нэгтгэн хүргүүллээ.

Аймгийн ХАҮТ, Жайка ОУБ-ын хамтарсан ХАА бүтээгдэхүүний нэмүү өртгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийг дэмжих төслийн саналыг сумдаас авч, Орхон сумаас ирүүлсэн Тэс-Оргил ХХК-ийн саналыг дэмжиж уламжиллаа.

Хөгжлийн Шийдэл ОУБ-ын Best хөтөлбөр, Шарын гол сумын ЗДТГ-тай хамтран төсөл сонгон шалгаруулах болон хяналтын Зөвлөлийн гишүүдэд “Сум хөгжүүлэх сангийн өнөөгийн байдал цаашид анхаарах асуудлууд” сургалт мэдээллийг 07 сарын 01-ний өдөр зохион байгуулж, 11 гишүүдэд мэдээлэл хүргэлээ.

Хөгжлийн Шийдэл ОУБ-ын Best хөтөлбөр, Эко ноос ХХК хамтран Дархан-Уул аймгийн “Малчдын хоршоо-Үндэсний үйлдвэр түүхий бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт” сургалт мэдээллийг 07 сарын 02-ны өдөр зохион байгуулж, 29 малчин, хоршооны гишүүдэд мэдээлэл хүргэлээ.

2021 боловсруулах уриншийн захиалгыг аж ахуйн нэгж иргэдээр гарган ХХААХҮЯ-нд хүргүүллээ. Нийт 86 аж ахуйн нэгж иргэд 11800 га уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөсөн байна. 2021 оны 07 дугаар сарын 03 ны байдлаар уриншийн 1 дүгээр боловсруулалтыг 9200 га талбайд хийж гүйцэтгэл 77.9 хувьтай байна

Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 22 аж ахуйн нэгж, 4 иргэн хаврын чийг хаалтыг 8900 га-д, үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг 9200 га-д хийсэн байна.

Аймгийн хэмжээнд тариалалтын мэдээг эцэслэн гаргаж ХХААХҮЯ-нд хүргүүлээ. Мэдээгээр нийт 20804 га талбайд тариалахаар төлөвлөснөөс 24590,6 га-д буюу 118.2 хувийн гүйцэтгэлтэй тариалалтын ажил хийгдэж дууссан байна. Үүнээс төмс 525.5 га талбайд, хүнсний ногоо 1446.1 га талбайд, үр тариа 18110 га талбайд, тосны ургамал 3807 га талбайд талбайд, малын тэжээл 702 га талбайд тус тус тариалсан байна.

Орхон, Хонгор сумдын үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн таримлын тариалалт, арчлалт, хураалт, тэжээл бэлтгэлийн ажлыг технологийн хугацаанд чанартай гүйцэтгэж хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулан бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэхийн тулд “Техник үйлчилгээний дундын төв” төслийг боловсруулан УИХ-ын гишүүд, ХХААХҮЯ-нд албан тоотоор хүргүүлээ.

Хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх, мал аж ахуйг газар тариалантай зөв хослуулах замаар хөрсний үржил шимийг сайжруулж уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариаланг хөгжүүлж, дотоодын хүнсний хэрэгцээг тогтвортойгоор бүрэн хангах зорилгоор "Атар-4" аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулан дэмжигдсэн байна.

Шүлхий, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээг зохион байгуулах ажилд Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын 30 өрхийн 480 толгой малаас шүлхий болон бог малын мялзан өвчний тандалт шинжилгээний дээж цуглууллаа.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, малын сэг зэм устгал халдваргүйтгэлийн ажлын тайланг гарган холбогдох мэргэжилтэнд хүргүүлэв.

Албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 01/289 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу мал, амьтны халдваргүй өвчин, зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг устгах, бэлчээр, бууц, хашаа байр, уст цэг, усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх, отор нүүдэл, малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах зорилго бүхий “Мал эмнэлэг, ариун цэврийн сарын аян”-ыг аймгийн хэмжээнд хаврын улиралд 03 дугаарсарын 15-ны өдрөөс эхлэн, намрын улиралд 09 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд тус тус зохион байгуулах, сарын аяны хүрээнд халдваргүйтгэл хийх талбайн хэмжээ, хугацааг тогтоох, шаардагдах ажиллах хүч, тээврийн хэрэгсэл, шатахуун болон шаардлагатай бусад зардлыг шийдвэрлэн, уг арга хэмжээнд орон нутгийн байгууллага, иргэд малчдыг татан оролцуулах зэрэг арга хэмжээг тусгасан аймгийн Засаг даргын “Аянзохион байгуулах тухай” 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 01/А-92 тоот захирамж гаргуулан, уг арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд нийтдээ 328656 м² талбайд халдваргүйтгэл хийсэн.

Зүй бусын хорогдлоор 1604 толгой мал хорогдсоноос 1604 ширхэг үхсэн мал, амьтны хүүр, сэг зэмийг цуглуулан устгалын 9 цэгт зохих зааврын дагуу булж устган ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллалаа. Устгалын арга хэмжээ 100 хувьтай явагдаж байна.

Хаврын мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн тайланг орон нутгийн нэгжүүдээс авах, мал эмнэлгийн нэгдсэн системтэй тулган

шалгах ажлын хүрээнд Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс хаврын урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлийн тайлан мэдээ, акт баримтыг хүлээн авч, мал эмнэлгийн нэгдсэн системд орсон мэдээлэлтэй тулган шалгаж байна. Тарилгын актын малын тоо системд орсон малын тооноос зөрөх, хийсэн вакцины зураг оруулаагүй байх зэрэг алдаа дутагдалууд гарч байна.

Саалийн үнээнд хийх тандалт шинжилгээнд цусны дээж цуглуулах/ Дархан, Хонгор суманд ажиллах ажлын хүрээнд аймгийн ИТХ-аар баталсан “Мал, амьтны эрүүл мэнд” дэд хөтөлбөрийн хүрээнд үхрийн бруцеллёз, сүрьеэ, лейкоз өвчнөөс эрүүлийг батлах зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны 05-р сарын 11-ний өдрийн 01-А/150 тоот захирамж гарч тандалт шинжилгээг зохион байгуулан ажиллаж байна. 5966 хээлтэгч, 1043 хээлтүүлэгч мал шинжилгээнд хамруулаад байна. Тандалтын ажил үргэлжилж байна

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлийн дагуу малын шилжилт хөдөлгөөний хязгаарлах талаар аймгийн Засаг даргын захирамж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа.

Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй”, “Онч сөрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг шалгаж хүлээн авсан. Үүнд:

1. Дархан сум 14 дүгээр баг. Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн авто зогсоол, хөлбөмбөгийн талбай /улаан шугам/
2. Хонгор сум 1 дүгээр баг “Дархан арьс ширний цогцолбор” ОНӨХХК/ Бог малын ноосгүй арьс боловсруулах үйлдвэр, бод малын арьс боловсруулах үйлдвэр /Улаан шугам/ /Улаан шугам/
3. Дархан сум 12 джгаар баг. 13-р хороолол Үндэсний эрх чөлөөний 3-р гудамж 317 тоот 108 айлын орон сууцны барилга /улаан шугам/
4. Шарын гол сум. Шайзгатын хорооллоос тосгоны эцсийн буудал, эрүүл мэндийн төвийн арын тойроогоос гандангийн тойрог хүртлэх хатуу хучилттай авто замын өргөтгөл. /улаан шугам/
5. Дархан сум 14 дүгээр баг. Нэгдсэн эмнэлэгийн авто зогсоол /Гүйцэтгэл/
6. Дархан сум 15 дугаар баг. “Дэлгэрэх бат дэвжих” ХХК-ний үйлчилгээний төвийн гадна цахилгаан хангамж. /улаан шугам/
7. Дархан сум 10 дугаар баг “Хийморь Гарден” хотхоны 144 айлын орон сууц. /улаан шугам/
8. Дархан сум. 8-р багийг 1-р багтай холбох авто зам. /Улаан шугам/
9. Хаягийн зургийн дагуу 20 иргэн, 7 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон.
10. Цагдаагийн газраас газар зүйн байршлыг тогтоолгохоор ирүүлсэн 13-н цэгийн солбицолыг зурагт оруулж байршлыг тодорхойлон Цагдаагийн газарт хүргүүлсэн.
11. Дархан сум. 1,3,8,13,15 дугаар баг “Дэд бүтэцийн хөгжил-Баянзүрх, Дархан, Сэлэнгэ төсөл” гудамжны гэрэлтүүлгийн ажил. /улаан шугам/
12. Орхон сум 1 дүгээр баг Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /улаан шугам/
13. Дархан сум Малчин баг Үнсэн сан №2 сэргээн байгуулах. /улаан шугам/

14. Хонгор сум 1 дүгээр баг Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга. /улаан шугам/

Аймгийн Засаг даргын 2021.05.20-ний өдрийн 01-А/157 дугаар захирамжаар Дархан сумын 8, 13-р багт 3 нэгж талбарт дуудлага худалдааг 2021.06.24-ний өдөр зохион байгуулсан. Дархан сумын 13-р баг 30-р хороолол, Үйлдвэрчний 1-144 тоот хаягт байрлах 9334м.кв худалдаа, үйлчилгээний зориулалттай газарт 2 оролцогч оролцож, 277618400 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.

Санхүүгийн хяналт, Аудитын албанаас хяналт шалгалт явуулж байгаатай холбоотой газрын төлбөр нөхөн ногдуулах, 223 иргэн, хуулийн этгээдийн төлөлт, ногдуулалтыг шалгаж нөхөн ногдууллаа. Мөн аймгийн Татварын хэлтэс, манай байгууллага хоорондын төлөлтийн зөрүүтэй иргэн, хуулийн этгээдийн төлбөрийг хянах, төлөлтийг тулгах ажлыг Аудитын мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүрт нь гаргаж өгч ажиллалаа.

Төсөл сонгон шалгаруулалтын **битүүмжилсэн материалыг 2021.07.21-2021-07-27-ны өдрийн 09:00-17:00 цаг хүртэл Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт** хүлээн авч байна.Төсөл сонгон шалгаруулалтын битүүмжилсэн материалыг хүлээн авах хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 5 өдөр буюу 2021.08.03-ны өдөр зохион байгуулахаар ажиллаж байна.

5-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажил дуусч байнгын ашиглалтад оруулах комиссын нарийн бичгээр ажиллаж ашиглалтад оруулсан.

Дархан сум, 13-р баг үйлдвэрийн раойн Бурхант эко асфальт компанийн 6кВ цахилгааны агаарын шугамын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Орхон суманд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн барилгын эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Хонгор сум, Үржил шимт яргайт ХХК- ийн 6кВ цахилгааны агаарын шугамын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Дархан сум 12-р баг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дархан-Уул аймаг, Дархан сум 13-р баг Аюултай хог хаягдал агуулах барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл авах хүсэлт өгсөний дагуу холбогдох техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж буй 3 барилга байгууламжийн ажлын явцыг үзэж аймгийн Засаг дарга болон ХОХБТХ-т 2 удаа танилцуулсан.

МОН3244/3245 төслийн хүрээнд цэвэрлэх байгууламжийн барилга байгууламжийн гадна инженерийн шугам сүлжээний ажил эхлэх зөвшөөрөл авах хүсэлтийн дагуу техникийн бичиг баримтыг судлаж ажил эхлэх зөвшөөрөл олгосон.

Дархан сум, 10-р баг, иргэн Б.Одгаригийн 144 айлын орон сууцны барилгын ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн материалыг судлаж ажил эхлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон.

Дархан, Шарын гол сумдад агаар дахь хүхэрлэг хийн /SO₂/ болон азотын давхар ислийн /NO₂/ дундаж агууламж агаарын чанарын MNS4585:2016 стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давж бохирдсон тохиолдолгүй. 07 дугаар сарын 01-21 ний байдлаар PM10 тоосонцрын хоногийн дундаж хамгийн их агууламж 0.063мг/м³ хүрсэн ба MNS4585:2016 стандартын хоногийн дундаж хүлцэх агууламжаас 2 удаа давж бохирдсон ба Агаарын чанарын индексийн үнэлгээгээр “ХЭВИЙН” түвшинд, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр агаарын чанарын стандарт шаардлага хангах боловч зарим хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай байсан.

Гадаргын усны химийн шинжилгээний сорьцыг 06 дугаар сарын 16-нд хөтөлбөрийн дагуу Хараа-Дархан дээд, Хараа-Дархан доод, Шарын гол-Автозамын гүүр, Шарын гол-Усны харуул, Хүйтэн-Шарын гол усны харуул гэсэн хяналтын 5 цэгээс дээж авч усны химийн шинжилгээгээр бохирдлын үзүүлэлтүүдийг тодорхойлсон.

Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн бохир ус нийлснээс доош Бүрэн толгойн орчмоос авсан дээжинд голын усанд ууссан хүчилтөрөгч /O₂/-ийн агууламж алдагдаагүй байна.

Голын усны бохирдлыг илэрхийлэх үзүүлэлтүүдийг гадаргын усны чанарын MNS4586:98 стандарттай харьцуулахад Хараа-Дархан дээд, Хараа-Дархан доод, Шарын гол-Автозамын гүүр, Шарын гол-Усны харуул, Хүйтэн-Шарын голд ПИЧ /перманганатын исэлдэх чанар/ ЗДХ-ээс 1.3-2.6 дахин давсан бохирдолтой байна.

Энэ сард Дархан хотын төв ЦБ-ийн цэвэрлэгээний чанар 81.3 % өмнөх сараас 1.1%-иар буурсан ба Шарын гол сумын ЦБ 81.9%, Салхит өртөөний ЦБ 85.0%, Хонгор сумын ЦБ 32.4 % байна. Цэвэршүүлээд гарч байгаа усан дахь Ж/Б-жинлэгдэх бодисын агууламж Хонгор сумын ЦБ-1.8 дахин, Шарын гол сумын ЦБ-1.5 дахин; БХХ₅-биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж Төв ЦБ-2.4, Хонгор сумын ЦБ-9.2, Салхит өртөөний ЦБ-1.2 дахин, Шарын гол сум ЦБ-1.6 дахин; ПИЧ /перманганатын исэлдэх чанар/ -Төв ЦБ-1.2, Хонгор сумын ЦБ-4.8 дахин; нийт азотын нэгдэл /NH₄/-Төв ЦБ-2.6, Хонгор сумын ЦБ-3.2, Салхит өртөөний ЦБ-1.7, Шарын гол сумын ЦБ-1.8 дахин давсан бохирдолтой ус голд нийлүүлсэн.

Цэвэрлэх байгууламжуудын хаягдал бохир усны цэвэрлэгээний чанарын 2021 оны 01-06 дугаар сарын дүнг харууллаа.

Хонгор сумын судалгааны Цайдам, Алтангадасын улаанбуудайн түрүүлэлтийн үе шат жигдэрч, 6-р бригадын буудайн түрүүлэлтийн үе шат эхэлсэн. Төмсний цэцэглэлтийн үе шат эхэлсэн. Ургамлын ургалтын байдал маш сайн байна. Буудайн дундаж өндөр Цайдамын талбайд 54 см, бусад талбайд 62-72 см, түрүүний урт 7-9 см, төмсний дундаж өндөр 33см байна.Буудайн бүтээгдхүүнт үзүүлэлтийг тодорхойлоход 1м² талбайд түрүүтэй иш 215-290 ш тооллогдсон.

Бэлчээрийн ургамлын ширэг-улалж болон зарим алаг өвсний төрлийн ургамлын үрийн боловсролтын үе шат жигдэрч байна. Үетэн ургамал саман ерхөг, нангиад цагаан суль цэцэглэлтийн үе шатны төгсгөл ажиглагдсан. Нийт ургамлын дундаж өндөр 17-22 см, ургамлын ургалт маш сайн байна.

Хүснэгт 3. Бэлчээрийн ургамлын ургалтын мэдээ

№	Сумдын нэр	Ургамлын нэр	Үе шат	Ургамлын өндөр, см	Ургалтын байдал
1	Дархан	Ширэг	Үр боловсролт	22	5
		Мангир	цэцэглэлт		
2	Шарын	Агь	Нахианы өсөлт	17	

	гол	Гичгэнэ Ширэг	Цэцэглэл Үр боловсролт		5
3	Орхон	Ерхөг	түрүүлэлт	18	5
		Гичгэнэ	Үр боловсролт		
		Ширэг	Үр боловсролт		
4	Хонгор	Агь	нахианы өсөлт	18	5
		Гичгэнэ	Үр боловсролт		
		Ширэг	Үр боловсролт		

Хонгор сумын судалгааны буудай, уриншилсан болон төмсний талбайн хөрсний 0-100 см гүнд чийгийн нөөцийг тодорхойлов. Хөрсний ашигтай чийгийн нөөц бүх гүндээ Алтангадасын талбай 4.3...12.1 мм-ээр буурсан, бусад талбайн чийг 8.6... 43.8 мм-ээр өссөн байна. Ашигтай чийгийн нөөцийг чийг багтаамжийн доод хязгаартай харьцуулахад нийт талбайн чийгийн нөөц хангалттай сайн байна.

2021 оны 07 дугаар сарын 20-ний байдлаар Хараа, Хүйтэн, Шарын голуудын усны түвшний тойм мэдээ.

	Голын нэр	Усны түвшин, см				Энэ сарын хамгийн их түвшин
		Аюултай үерийн түвшин	Үерийн түвшин	Энэ сарын дундаж түвшин	Тунадас мм	
1	Хараа гол / Бүрэн толгой/ орчмоор	214 см	172	188	68,8 мм	191 см
2	Шарын гол / Орхон сум / орчмоор	381 см	294	277	31,8 мм	279 см
3	Хүйтэний гол / Зулзага / орчмоор	343 см	311	313	102 мм	321 см

Хараа, Хүйтэний голуудын усны түвшин өмнөх сараас төдийлөн багасаагүй, үерийн түвшинг 5-20 см давж, зарим налуу хэсгээр ус эрэгээ хальсан байдалтай байлаа. 07 дугаар сарын 21-ны байдлаар Хараа голын усны түвшин үерийн түвшинг 13 см давсан, Шарын голын усны түвшин 253 см ОЖД-аас 24 см их, Хүйтэний голын усны түвшин 295 см ОЖД-аас 71 см их байна.

Мэргэжлийн хяналтын газраас тайлант хугацаанд Төлөвлөгөөт шалгалт-2, Зөвлөн туслах үйлчилгээ-3, төлөвлөгөөт бус шалгалт 3, урьдчилан сэргийлэх шалгалт 2, баталгаажилт-4 нийт 14 ААНБ, 5 иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 12 зөрчил илрүүлж, 3 зөрчлийг газар дээр нь арилгуулсан, бага эрсдэлтэй 10, дунд эрсдэлтэй 3, 1 их эрсдэлтэй дүгнэгдсэн байна.

Тус газарт 2021 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 07 дугаар сарын 20-ныг дуустал нийт 67 албан бичиг ирсэн, үүнээс 8 хариутай, 59 хариугүй 13 өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэж шийдвэрлэсэн.

ЭИХХЦХХ: 10 ААН-ийн 701,7 т бодис бараа бүтээгдэхүүн, 2 вагон хус модон хуулганд хяналт хийж 20 дээж авч, 2 ургамлын импортын гэрчилгээ, 3 ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ, 1 гэрчилгээ баталгаажуулан хяналтаас чөлөөлж ажилласан.

ОХУ-аас импортлосон 420тн хүнсний улаан буудай, 67 т тэжээлийн овъёос, 8 дээжэнд хяналт хийсэн. ОХУ-аас импортлогдсон 8,8 т чихэр, 11,7 т жигнэмэгнээс нийт 11 дээж авч МХГ-ийн лабораторид хүргүүлсэн. ОХУ-аас импортлосон 65,2 т

растворитель, 646, 647 дугаартай будаг шингэлэгч, 38,7 т уул уурхайн тэсэлгээний бодисонд хяналт хийж хяналтаас чөлөөлж ажилласан. ОХУ импортлосон 30,3 т хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, 20тн тарвас буулгахад хяналт тавьж ажилласан.

2 ААН-ийн БНХАУ-руу экспортлосон 40тн хивэг, 2 вагон хус модон хуулганд хяналт хийж хяналт хийж 1 дээж авч шинжлүүлж, шинжилгээний дүнд үндэслэн 3 ургамлын эрүүл ахуйн гэрчилгээг олгон 1 гэрчилгээ баталгаажуулсан.

Алтанбулаг боомтоор орж ирсэн 3 ТИР машин 50,3 т бараа бүтээгдэхүүн Дархан-Уул аймагт буулт хийхэд 3 удаагийн хяналт тавьж, халдваргүйтгэлийг мал эмнэлгийн газраар хийлгэсэн.

Нийт давхардсан тоогоор 100 аж ахуй нэгж, 9 иргэний хүсэлтээр 103 дээжинд 305 үзүүлэлтээр шинжилгээ хийж гүйцэтгэсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/38 дугаартай удирдамжийн дагуу 5 ААНБ-т урьдчилан сэргийлэх хяналт хийж зураг төслийн боловсруулалт, материалын чанар, угсралтын ажлын гүйцэтгэлийг шалгалаа. Шалгалтаар бетоны цутгалтын технологи зөрчсөн 1, зөвшөөрөлгүйгээр ажил гүйцэтгэсэн 1 зөрчил дутагдал илэрч, 100% арилгуулсан. 2 ААНБ-т барилгын ашиглалтын тухай улсын байцаагчийн дүгнэлт гарган хүргүүлсэн.

МХЕГ-ын даргын баталсан 01/10 дугаартай “Ашигт малтмалыг хууль бусаар олборлох эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу 4 ААН, 8 бичил уурхайн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд хамтарсан шалгалт хийсэн. Шалгалтаар ААНБ-ын бичиг баримтын бүрдэлт 85%, нөхөрлөлүүд бичиг баримтын бүрдэлт 100% байна. уулын ажлын төлөвлөгөө, БОМТ-ний дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Нийт 4 зөрчил илрүүлэн, зөрчлийг арилгах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Зөвшөөрөлгүйгээр газрын хэвлийд халдсан 1 зөрчил илрүүлэн Зөрчлийн хэрэг нээн шалгахаар болсон. Шалгалт үргэлжилж байна.

Дархан сумын Малчин багийн иргэн Б.Гантулгын мал аж ахуйд төлөвлөгөөт шалгалт хийж холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд бага эрсдэлтэй дүгнэгдсэн. Шалгалтаар 4 алдаа дутагдал илрүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Мөнх дөл дэвжих ХХК хяналт шалгалт хийхэд эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар их хүнсний чанар, стандартын хяналтаар дунд эрсдэлтэй дүгнэгдсэн. Шалгалтаар 34 алдаа дутагдал илрүүлэн 5 буюу 14.7%-ийг арилгуулсан. Тус байгууллагад 10-02-041/01 дугаартай хугацаатай хамтарсан албан шаардлага хүргүүлээд байна.

“Дархан минж” ХХК-ийн “Гранд Як”-ийн гоо сайхны газарт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд бага эрсдэлтэй дүгнэгдсэн. Зөвлөн туслах үйлчилгээгээр 13 алдаа дутагдал илрүүлэн 5 буюу 38.4%-ийг арилгуулсан.

Эйс энд Эй трейд ХХК-ийн инженерийн шугам сүлжээний ажилд хөтөлбөрийн дагуу ЗТҮ-г үзүүлж, 5.37.1 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 4% бага эрсдэлтэй дүгнэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт дунджаар 95% биелэгдэж байна. Хөтөлбөрийн хүрээнд нийт 2 дутагдал илэрч, 2 дутагдлыг арилгуулсан.

Байгууллагын 2021 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө аймгийн МХГ-ын даргын баталсан 10/147 дугаартай удирдамжийн дагуу УШТХүрээлэнд

зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Хяналтын хуудсаар эрсдэл үүсэх магадлал 67% буюу эрсдэл их үнэлэгдэж 14 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Эрүүл ахуйн хяналтаар Өег гурил ХХК-ийн ирүүлсэн хүсэлтийн дагуу МХГ-ын даргын баталсан 10/205 тоот “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжаар төвлөрсөн сүлжээний усан хангамжийн Ундны усны төвлөрсөн сүлжээний усан хангамж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, ажлын байрнаас “Усны чанар.Дээж авах заавар”. MNS ISO 5667-5:2001 стандарт, МХЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/167 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Эрүүл ахуйн нян судлалын шинжилгээнд дээж авах аргачлал”-ын дагуу шинжилгээ авч чанар аюулгүй байдлыг тодорхойлох зорилгоор төлөвлөгөөт бус хяналт хийж, төвлөрсөн сүлжээнээс 2 дээж, үйлдвэрийн тоног төхөөрөмж, ажлын байрнаас 20 ширхэг арчдас авч МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэхэд стандартын шаардлага хангасан тул хариуг хүргүүлэн ажилласан.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 16-р цэцэрлэгийн нэр бүхий багш нараас “цалин хөлсний тухай” төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтын 4.6 кодтой хяналтын хуудсаар үнэлэхэд 14% буюу эрсдэл үүсэх магадлал бага үнэлгээтэй үнэлэгдсэн.

МХЕГ-ын 01/37 тоот удирдамжийн дагуу Баян брижд ХХК-ийн нийтийн орон сууцны 2 лифт, Дархан Өргөө-6 кинотеатрын 2 лифт, иргэний эзэмшилд байдаг 1 манипулятор краны техникийн магадлалын актыг хянаж, ашиглах зөвшөөрөл олгосон.

Шинээр баригдсан инженерийн шугам сүлжээний ажилыг ашиглалтанд хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд ажиллаж дутуу ажлуудыг гүйцээх талаар санал хүргүүлсэн.

Хөдөлмөрийн хяналт: Людвиг Пфайффер Хох унд Тиефбай ХХК, Дархан-Уул аймгийн Цагдаагийн газарт гарсан үйлдвэрлэлийн ослын актыг хянан баталгаажуулж, цахим системд бүртгэлээ.

ҮМСТЛаборатори: 4 ААНБ, 4 иргэний нийт 54,4кг буюу 27ш гулдмай хайлж сорьцолсоноос 50,7кг 27ш гулдмайд сорьцын баталгаа олгосон.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 105, 2021 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2021 оны 07 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхим нээлттэй дуудлага худалдааг зохион байгуулж ажилласан. Нээлттэй дуудлага худалдаагаар аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 4 тээврийн хэрэгсэл, аймгийн Байгаль орчин аялал жуучлалын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсан 2 тээврийн хэрэгслүүдийг тус тус худалдан борлуулж 27 сая төгрөгийг төвлөрүүллээ.

Тус газрын 2021 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гарган аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогчоор баталгаажуулж, 2022 оны төсвийн төсөл болон орон нутгийн өмчийн түрээсийн төлбөр, орон нутгийн өмчийг худалдан борлуулснаас орох орлогын төлөвлөгөөг гарган аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

Аймгийн Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн ээлжит хурлыг 2021 оны 07 дугаар сарын 09-ны өдөр цахимаар зохион байгуулж, аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын нийт 55,214,227.78₮ төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг хэлэлцүүлэн, гишүүдийн 100% саналаар акталж, данснаас хасах шийдвэрийг дэмжиж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.

Дархан-Уул аймагт эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэн малын үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээний хүрээнд Хонгор сумын Хар бэлчирт байрлах фермерийн мал аж ахуйд 2020 онд төллөсөн 48 бярууг худалдан авах хүсэлт ирүүлсэн иргэн, аж ахуй нэгжид хуваарилан гэрээний дагуу худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 7,611.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3.482.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 418.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 135.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Япон улсын засгийн газрын өвсний үндэс хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих /142.361 доллар/ 405.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, нийт 12,054.2 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй 57 төсөл арга хэмжээний худалдан авалтыг 96 хувийн гүйцэтгэлтэй, 282.6 сая төгрөгийн хэмнэлт үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

Тендер нь зарлагдсан 2,220.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8, хүчингүй болж дахин зарлагдах 489.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, гэрээ байгуулах эрх олгосон 8,293.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 45, захиалагчаас материал ирээгүй, зохион байгуулагдаагүй 1,049.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ тус тус байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Засгийн газрын хэрэг эрхлэх газраас 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1, Барилга хот байгуулалтын яамнаас 3,100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3, Боловсрол шинжлэх ухааны яамнаас 1,060,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4, Соёлын яамнаас 5,000,0 төгрөгийн төсөвт өртөгтэй, 1, Зам тээвэр хөгжлийн яамнаас 41,044.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 4 төсөл, арга хэмжээ, Эрүүл мэндийн яамнаас 486.0 сая төгрөгийн 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 107.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Биеийн тамир спортын хорооноос 3,500.0 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй 1, нийт 54,697.5 сая төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, 17 төсөл, арга хэмжээ тус тус эрх шилжигдэн ирснийг 100 хувийн гүйцэтгэлтэй, 288.9 сая төгрөгийн хэмнэлт, үр ашигтай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:

Тендер нь зарлагдсан 30,401.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, гэрээ байгуулах эрх олгосон 24,296.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ тус тус байна.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР